

Үйл ажиллагааны зарим судалгааг ашиглах тухай

Л. Бархас, Австралийн Моносны Их Сургууль,
судлаач оюутан

Үйл ажиллагааны судалгаа нь 1940-оод оноос үүсэж хөгжссөн судалгааны нэг аргачлал богоод “тулгарсан асуудалд практик шийдэл олохын тулд оролцооны үндсэн дээр үйл ажиллагаа ба эргэцүүлэл, онол ба практикийг хамтад нь авч үзэхийг оролддог”. Үйл ажиллагааны судалгаа гэсэн өрөнхий нэрийн дор үйл ажиллагааны оролцоот судалгаа, үйл ажиллагааны шинжлэх ухаан, софт системийн аргачлал зэрэг вор хоорондоо ялгаатай олон хувилбар багтана. Хийж байж л мэдэж авна, хийнгээ сурах нь суралцах хамгийн сайн арга гэсэн итгэл дээр сууриндаг, оролцогчдын түршилагыг судлаачийн мэдлэгтэй дүйцэхүүц адил түвшинд авчирч үнэлдэг, практик үр дүнг чухалчилдаг зэрэг хэд хэдэн давуу талтай. Уг аргачлалыг Монголд боловсролын салбар, ядуурлыг бууруулах арга хэмжээнээс гадна байгууллагын ворчлолт, хөгжлийн хүрээнд ашиглах боломжтой. Мон энэ талаар арга зүйн дэмжлэг авах хэрэгцээг судлах хэрэгтэй байна.

Түлхүүр үгс: онол, практик, баримт, оролцоо, уян систем,
софт систем, үйл ажиллагааны судалгаа

Үүсэл

Үйл ажиллагааны судалгаа буюу *action research* гэсэн нэр томъёог анх Курт Левин 1940-оод оны эхэн үед хэрэглэсэн гэж үздэг. 1946 онд нийтлэгдсэн америкийн олон нийтийн бүлгүүдийн хоорондын харилцааны талаарх “Үйл ажиллагааны судалгаа ба цөөнхийн асуудал” бүтээлдээ “нийгмийн практикт ямар судалгаа шаардлагатай вэ гэвэл нийгмийн менежментийн эсвэл нийгмийн инженерчлэлийн судалгаа гэж хэлж болно. Энэ нь нэгэн төрлийн үйл ажиллагааны судалгаа бөгөөд нийгмийн үйлдлийн янз бүрийн хэлбэрийн нөхцөл, үр дагаврын харьцуулсан судалгаа, нийгмийн үйлдэл рүү чиглэсэн судалгаа юм. Зөвхөн ном үйлдвэрлэдэг судалгаа хангалттай биш. Гэхдээ энэ нь нийгмийн цэвэр шинжлэх ухааны талбарт шаардагддагаас шинжлэх ухаанч байдлаараа арай сүлч юмуу, “доогуур” судалгаа гэсэн үг огт биш” гэсэн байдал (Левин.К, 1946). Түүний “Аливаа зүйлийг ойлгох хамгийн сайн арга бол өөрчлөхийг оролдох явдал”, “Сайн онол шиг практик зүйл байхгүй” гэсэн үгийг олон судлаач иш татдаг билээ (Брайдон-Миллер нар, 2003).

Мөн энэ үед Жон Коллер американын угуул иргэд болон цагаан арьстнуудын харилцааны талаарх бүтээлдээ үндэстэн угсаатны харилцаан дахь зан үйлийг өөрчлөхөд судалгаа хамгийн чухал, гэхдээ судалгааг судлаач болон энгийн хүмүүс хамтран хийх шаардлагатай тухай, ердийн судалгааны хүрээнд сонирхолтой ажиглалт хийж болох боловч тэр нь хүмүүсийн итгэл үнэмшлийг өөрчлөхөд нөлөөлж чадахгүй тухай дурдсан. Левин, Коллер нар ойролцоо цаг үед төстэй санаануудыг дэвшүүлсэн ч Курт Левиний нэр судлаачдын дунд илүүтэй танигдсан байдал (Пасмор, 2006). Үйл ажиллагааны судалгааны үүслийн тухай ярьж байгаа тохиолдолд Жон Дювийн нөлөө зайлшгүй дурдагдана. Боловсрол, сургалтыг ардчиллаа талаар их бичсэн бөгөөд практик асуудалд практик шийдэл хэрэгтэй, аливаа шийдлийг практикт хүссэн үр дүнг гаргаж байгаа эсэхээр нь үнэлэх хэрэгтэй гэж үзэж байв (Пасмор, 2006). Үйл ажиллааганы судалгааны онол, практикт нөлөө үзүүлсэн олон урсгалын нэг нь прагматизм бөгөөд арай сүүлийн үсийн төлөөлөгчдөөс Ричард Рортийг дурдаж болох юм (Ризон, 2003).

Үйл ажиллагааны судалгааны тодорхойлолт, онцлог шинж

Үйл ажиллагааны судалгаа гэдэг нь өрөнхий нэр бөгөөд “оролцооны судалгаа, ажлын байран дээрх судалгаа, үйл ажиллагааны шинжлэх ухаан, хамтран гүйцэтгэх судалгаа, сурган хийх судалгаа, эзрэг талаас нь үнэлэн хийх судалгаа, олон нийтэд тулгуурласан оролцооны судалгаа, багшийн судалгаа, хөдөөгийн оролцоот үнэлгээ, феминист судалгаа, арьсны өнгөөр ялгаварлахын эсрэг оролцооны судалгаа ...” (Херр, Андерсон, 2005) зэрэг янз бүрийн нэрээр олны танил болсон байдаг. Үйл ажиллагааны судалгааны талаар нийтлэгдсэн бүтээлийн тоймоос харахад үйл ажиллагааны судалгааг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн салбарт болон байгууллагын хөгжил, нутгийн хөгжил зэрэг чиглэлд түлхүү ашиглаж байна (Дик Б, 2004, 2007).

Үйл ажиллагааны судалгаа нь дангаараа бие даасан нэг салбар биш (Гринвуд, Левин, 2007; Брайдон-Миллер нар, 2003), олон чиглэл салбарт салангийн хөгжиж байгаа тул бүхий л салбарыг хамарсан нэг тодорхойлолт өгөхөд бэрхшээлтэй бололтой. Тухайлбал, Боб Дик үйл ажиллагааны судалгаа гэдэг нь үйл ажиллагаа явуулах буюу арга хэмжээ авах, судалгаа хийх гэсэн хос зорилго бүхий аргачлал гэсэн хамгийн энгийн тодорхойлолт өгчээ. Харин үйл ажиллагааны судалгааны олон чиглэл урсгалын онцлогийг нэгтгэн харуулах талаар ажиллан “Үйл ажиллагааны судалгааны гарын авлага” гэсэн номыг эмхэтгэн гаргасан Ризон, Брэдбюри нар (2007) “мэдэхүй болон мэдлэгийг системтэй бий болгох практик”, “үйл ажиллагааны судалгааны үндсэн зорилго бол хүмүүст өдөр тутмын амьдралд нь хэрэг болох практик мэдлэг бий болгох”, “энэхүү практик мэдлэгээр дамжуулан хүмүүсийн эдийн засаг, улс төр, сэтгэл зүй, оюун санааны сайн сайхан байдлыг дээшлүүлэх явдал” гэж үзсэн бөгөөд “тулгарсан асуудалд практик

шийдэл олохын тулд оролцооны үндсэн дээр үйл ажиллагаа ба эргэцүүлэл, онол ба практикийг хамтад нь авч үзэхийг оролддог” гэжээ.

Гринвуд, Левин нар (2007) үйл ажиллагааны судалгаанд түгээмэл тохиолдох дараах хэдэн шинжийг тодорхойлсон байна. Үүнд:

- тухайн орчин нөхцлөөсөө хамааралтай бөгөөд бодит амьдралд тохиолдож буй асуудлыг цогцоор нь шийднэ;
- судалгааны оролцогч, судлаачид хамтдаа мэдлэгийг бүтээх бөгөөд оролцогчдын хувь нэмрийг зохих ёсоор үнэлнэ;
- тухайн бүлэгт байгаа хүмүүсийн туршлага, чадварын ялгаатай байдлыг судалгаа-үйл ажиллагаа гэсэн үйл явцыг илүү баялаг болгох боломж гэж үзнэ;
- судлах явцад олж мэдсэн зүйлдээ тулгуурлан арга хэмжээ авах бөгөөд эдгээр арга хэмжээний талаар эргэцүүлэн бодсоноор дахин шинэ зүйл, утга учрыг олж мэднэ;
- тухайн үйл ажиллагааны судалгааны явцад олж авсан мэдлэгийн найдвартай байдал, хүчин төгөлдөр байдлыг уг үйл явцаас урган гарсан үйл ажиллагаа, арга хэмжээ нь тухайн асуудлыг шийдсэн эсэхээр, мөн судалгааны оролцогчид тухайн нөхцөл байдлыг өөрсдөө удирдан залах байдал нь дээшилсэн эсэхээр хэмжинэ.

Түүнчлэн үйл ажиллагааны судалгаа нь ихэвчлэн цикл маягаар давтан явагддаг, тухайн нөхцөл байдлаасаа шалтгаалаад, “төлөвлөх, гүйцэтгэх, үнэлэх”, эсвэл “оношлох, арга хэмжээ авах, эргэцүүлэх” зэргээр судлаачид өөр өөрөөр нэрлэсэн байдаг. Үйл ажиллагааны судалгаа нь заавал чанарын эсвэл тоон байх ёстой гэсэн хязгаарлалт байхгүй. Асуулга, статистик дүн шинжилгээ, ярилцлага, фокус бүлэг, амьдралын түүх зэрэг нийгмийн судалгааны

бүхий л арга техникийг ашиглах боломжтой (Гринвуд, Левин, 2007).

Үйл ажиллагааны судалгаа нь нийгмийн судалгааны ердийн аргачлалаас хэд хэдэн зүйлээр ялгаатай. Тухайлбал, нийгмийн ухааны уламжлалт судалгааны хувьд объектив байх зарчмыг эрхэмлэн судлаач судалгааны үйл явц, үр дүнд нөлөөлөхгүй байхыг шаарддаг бол үйл ажиллагааны судалгаанд судлаач идэвхтэй байр сууринаас оролцох шаардлагатай байдаг. Ердийн судалгаанд судлаач, судлуулагч хоёр тусдаа байдаг бол үйл ажиллагааны судалгаанд тэд тэгш байр суурь эзлэх бөгөөд аль аль нь судалгаа, практик арга хэмжээнд оролцно. Ердийн судалгааны хувьд судалгаа, практик хоёр тусдаа оршдог бол үйл ажиллагааны судалгаа нь судалгаа, практик арга хэмжээний хоорондох зайн баагасгахыг хичээдэг.

Үйл ажиллагааны судалгааг хийж эсвэл удирдан зохион байгуулсан 25 жилийн туршлага дээрээ тулгуурлан Сомех (2006) арга зүйн дараах зарчмуудыг боловсруулсан байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны судалгаа нь судалгаа ба үйлдлийг цуврал цикл цогц байдлаар нэгтгэн авч үздэг.
2. Үйл ажиллагааны судалгааг оролцогч ба судлаачид хамтран хэрэгжүүлэх бөгөөд тэдний гүйцэтгэх үүрэг нь хатуу тогтсон биш, харилцан бие биеэ дэмжих боломжтой байна.
3. Үйл ажиллагааны судалгаа нь бодит орчин нөхцөл байдлын талаар давтагдашгүй мэдлэг, ойлголт бий болгоно.
4. Үйл ажиллагааны судалгаа нь нийгмийн шударга ёсны төлөөх алсын зорилго, тэмүүллээс эх авна.
5. Үйл ажиллагааны судалгаа нь судалгааны туршид судлаачаас өөрийн гүйцэтгэж буй үүргийн талаар маш ондөр түвшинд эргэцүүлэн бodoх,

мэдрэмжтэй байхыг шаарддаг.

6. Үйл ажиллагааны судалгаа нь сэтгэл судлал, философ, социологи гэх мэт нийгмийн ухааны бусад салбарын бий болгосон мэдлэгээс эрэл хийж, судлахыг шаарддаг. Гэхдээ шууд хүлээн авна гэсэн үг биш, харин цуглуванс судалгааны баримттай холбогдуулан шалгаж, дүн шинжилгээ хийхдээ харгалзан үзнэ гэсэн үг юм.
7. Үйл ажиллагааны судалгаа нь судалгаа хийх, практикаа эргэцүүлэн бодохыг шаарддагаараа оролцогчдод суралцах маш их боломж олгодог.
8. Үйл ажиллагааны судалгаа нь тухайн судалгааг түүх, улс төр, ёс суртахууны өргөн хүрээтэй орчинд байршуулдаг.

Үйл ажиллагааны судалгааны зарим чиглэл

Үйл ажиллагааны судалгаа нь янз бүрийн салбарт олон хэлбэрээр хийгдэж байгаа тул нэг хэлбэр, аргыг голлон ашигладаг судлаач бусад аргын талаар бараг мэдэхгүй байх боломжтой юм.

Түүнчлэн бие биеэсээ хамааралгүй салангий үүсэн хөгжсөнөөс үүдэн түгээмэл хэрэглэгдэж буй аргачлалуудыг хооронд нь харьцуулан, онцлогийг тусган, ямар нөхцөлд аль нь илүү зохимжтойг үнэлсэн судалгаа, тайлбар цөөн байна. Тиймээс арай түгээмэл хэрэглэгдэж буй үйл ажиллагааны оролцоот судалгаа, үйл ажиллагааны шинжлэх ухаан, софт буюу уян системийн аргачлал зэрэг хэд хэдэн гол аргачлалын талаар өрөнхий байдлыар товчхон дурдья.

Үйл ажиллагааны оролцоот судалгаа (*Participatory Action Research-PAR*). Үйл ажиллагааны судалгааны хамгийн түгээмэл хэлбэрийн нэг боловч дотроо бас мэдэгдэхүйц ялгаатай урсгалууд бий. Улс төр, эдийн засгийн эрх мэдлийн харилцааны дүн шинжилгээн дээр тулгуурлан, эрх мэдлийн харилцааг өөрчилж, тэгш биш

байдлыг багасгаагүй цагт нийгмийн дорвитой өөрчлөлт хийгдэхгүй гэж үздэг нийтлэг талтай (Гринвуд, Левин, 2007). Судлаач Фрейр нь боловсролын салбар дахь үйл ажиллагааны оролцоот судалгаанд томоохон нөлөө үзүүлсэн бөгөөд багш нар хүүхдэд мэдээлэл өгөх гэж оролдог, гэтэл жинхэнэ боловсрол бол зөвхөн практик буюу эргэцүүлэл, үйл ажиллагаагаар дамжин явагдах бөгөөд үйл ажиллагааны үр дагавар эргэцүүллийн объект болно гэж үзжээ (Сомех, 2006).

Үйл ажиллагааны оролцоот судалгааг хөгжиж буй орнуудын нөхцөл байдлыг сайжруулах аргачлал болгон хөгжүүлж, ашиглаж, дэлгэрүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн төлөөлөгчийн нэг нь Орланда Фалс Борда юм. Тэрээр их сургуулийн танхимаас гарч Латин Америкийн хөдөөгийн багуудтай ажилласан бөгөөд бүтээлдээ тухайн практикт ямар онол үйлчилж байгааг баримтжуулахын зэрэгцээ ямар арга хэмжээ хүссэн үр дүнд хүргэж байгааг тэмдэглэсэн. 1970 оноос хойш энэ чиглэлээр ажиллаж буй Фалс Борда үйл ажиллагааны оролцоот судалгаа нь судалгааны аргачлал төдийгүй амьдралын гүн ухаан гэж үзж байна (Фалс Борда, 2007)

Хөгжиж буй орнуудад тусlamж үзүүлэх олон улсын байгууллагууд үйл ажиллагааны оролцоот судалгааг түгээмэл ашиглаж байна. Тиймээс үйл ажиллагааны оролцоот судалгааны жишээг олоход арай хялбар. Тухайлбал, дайны дараах Гватемалын ядуу тосгон ч юм уу, Танзаний эмэгтэйчүүдийн дунд ч юм уу үйл ажиллагааны судалгааг ашиглан хүмүүс өөрсдийн амьдралд өөрчлөлт гаргасан жишээ, нийтлэгдсэн судалгааны тайлан олон байна. Монголд бэлчээрийн менежмент, байгаль орчны хамгааллын чиглэлээр үйл ажиллагааны оролцоот судалгааг Канадын олон улсын хөгжлийн агентлагийн санхүүжилт бүхий төслийн хүрээнд хийж байсан (Ыханбай нар,

2006). Мөн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, Дэлхийн банкны санхүүжилт бүхий зарим төслийн хүрээнд үйл ажиллагааны оролцоот судалгааны зарим нэг хэлбэр эсвэл элементийг хэрэглэж байна.

Хэдийгээр олон улсын хөгжлийн байгууллагууд оролцоог эрхэмлэсэн, үйл ажиллагаанд чиглэсэн судалгааг дэмжиж байгаа боловч өөрсдөө маш шаталсан бүтэцтэй, эрх мэдлийн харилцаа хүчтэй, арчилсан байдлаар хэрхэн ажиллах талаар хандлага, ур чадвар дутмаг байгааг судлаачид тэмдэглэсэн байна (Брайдон-Миллер нар, 2003).

Үйл ажиллагааны шинжлэх ухаан (*Action Science*). Энэ аргачлалыг зарим судлаач үйл ажиллагааны судалгааг шинжлэх ухаанч байдал, практик ач холбогдлын аль алийг нь хангасан байдлаар хөгжүүлэхийг эрмэлзсэн хамгийн системтэй оролдлого гэж үздэг (Гринвуд, Левин, 2007). Бусад урсгалын нэгэн адил онол, практикийн харилцаа анхаарлын төвд байdag бөгөөд нийгмийн аль нэг үзэгдлийг тайлбарласан онол бий болгон, улмаар тэрхүү онолын үндсэн дээр үйл ажиллагаа явуулах, энэ явцдаа шинжлэх ухааны шалгуурыг мөн хангах замаар нийгмийн судалгаа, нийгмийн практикийн хоорондын зайлгүүлэхийг бий болгон ашигласан. (Фридман, 2007).

Энэ урсгалын гол төлөөлөгч болох Аргирис, Шон нар хүмүүс бие биетэйгээ харилцаадаа юу төлөвлөж, яаж хэрэгжүүлдэг тухай онол дэвшүүлэн, баримталж буй онол (*espoused theory*) болон хэрэглэж буй онол (*theory-in-use*) гэсэн ойлголтыг бий болгон ашигласан. Баримталж буй онол гэдэг нь хүмүүс аливаа үйлдлээ тайлбарлахдаа ямар онол баримталж байгааг, харин хэрэглэж буй онол гэдэг нь үйлдлийг ажиглагч шинжлээд, уг үйлдэлд ийм онол хэрэглэсэн байна гэж тогтоосон онол юм. Энэ нь цоо шинэ ойлголт биш боловч үйл ажиллагааны шинжлэх ухааны аргачлал нь дээрх баримталж буй онол, хэрэглэж буй онолын хоорондын зайлгүүлэхийг бий болгон ашигласан. (Фридман, 2007).

ялгааг тухайн нөхцөл байдлыг өөрчлөх, сайжруулах арга болгож байгаа нь шинэлэг гэж үздэг байна (Гринвуд, Левин, 2007). Тухайлбал, байгууллагад хэдийгээр албан ёсоор гаргасан дүрэм журам үйлчлэх боловч ажиллагчид практик дээр өөрийн дүрэм журмыг бий болгосон байдаг. Тиймээс ажиллагчид чухам ямар онол хэрэглэж байгааг, асуудлын цаад учир шалтгааныг судлах нь байгууллагад өөрчлөлт хийхэд маш чухал гэж үздэг. Аргирис нар (1985) үйл ажиллагааны шинжлэх ухааны судлаач гэдэг бол үйлчлүүлэгчийн системд суралцах явц бий болгох, ерөнхий мэдлэгт хувь нэмэр оруулахын аль алийг нь зорилго болгосон хөндлөнгөөс оролцогч юм гэсэн байна. Энэ аргыг байгууллагын хөгжлийн зорилгоор болон бизнесийн салбарт ашигласан жишээ нэлээд байна.

Софт системийн аргачлал (Soft Systems Methodology-SSM). Энэхүү аргачлалыг системийн сэтгэлгээний хүрээнд хамгийн сайн хэлцэгдсэн, баримтжуулсан аргачлал гэж үздэг бөгөөд гол төлөөлөгч нь Чекланд (1981) юм. Тэрээр уг аргачлалд хэрэглэгдэх дараах долоон үе шатыг дурдаж тайлбарласан. Үүнд: 1/ асуудал үүснэ. 2/ асуудлыг илэрхийлнэ, гэхдээ ямар нэг загвар, бүтэц ашиглахаас зайлсхийнэ. 3/ тухайн асуудлыг хамаатуулж болох системтэй холбож, тэрхүү системийн суурь тодорхойлолтуудыг өгнө. 4/ дээрх тодорхойлолтуудад тулгуурлан тухайн үйлдлийг тайлбарлах онолыг хүрээг гаргана. 5/ тэрхүү онолын хүрээг 2 дугаар үе шатанд илэрхийлсэн асуудалтай харьцуулж үзнэ. 6/ юуг өөрчилмөөр байгааг болон юуг өөрчлөх боломжтой гэсэн хоёр чиглэлээр өөрчлөлтийн санал бэлтгэнэ. 7/ тохирсон өөрчлөлтөө хэрэгжүүлнэ. Энэ үе шатуудын аль нэгэнд эргээд асуудал үүсэхэд дахин 1 дүгээр үе шатаас эхэлнэ (Флад, Р, 2006). Зарим судлаач энэхүү аргыг мэдээллийн системд дүн шинжилгээ хийхэд илүү тохиромжтой гэж үздэг ч заавал үүгээр хязгаарлагдахгүй.

Монголд үйл ажиллагааны судалгааг ашиглах тухай зарим санал

Үйл ажиллагааны судалгаа нь сүүлийн үед харьцангуй эрчимтэй хөгжиж байгаа боловч ердийн нийгмийн судалгаатай харьцуулахад маш бага байгаа юм. Мөн үйл ажиллагааны судалгааны хүрээнд болон доторх янз бүрийн аргачлалын хүрээнд шийдвэрлэгдээгүй асуудал, хэлцэгдэх түвшинд байгаа олон асуудал байна. Тухайлбал, ихэнх судалгааг тодорхой тохиолдол дээр хийж байгаа учраас түүнийг арай өргөн хүрээнд, нийгмийн түвшинд авчрах ямар боломж байна вэ, судалгааны чанарыг хэрхэн дээшлүүлэх вэ, хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хэрхэн сайжруулах вэ гэх мэт. Оюутнуудад уг судалгааны аргыг хэрхэн заах талаар аргачлал сүл хөгжсөн бөгөөд энэ талаар зарим нэг арга хэмжээ авч байгаагийн нэг бол 2007 оны 9 дүгээр сарын Action Research буюу Үйл ажиллагааны судалгаа гэсэн сэтгүүлийн дугаар бүхэлдээ уг судалгааг заах аргачлалд зориулагджээ. Үйл ажиллагааны судалгаа нь практикт өөрчлөлт гаргах, байгаа нөхцөл байдлыг сайжруулахад чиглэдэг, гаднаас ямар нэгэн бэлэн заавраар бус тухайн асуудалтай тулгараад байгаа хамт олон, бүлэг, байгууллага өөрслөө асуудлаа тодорхойлж, судалгаагаа хийж, арга хэмжээ авч, үр дүнгээ үнэлэх боломж олгодгоороо Монголын өнөөгийн нөхцөл байдалд хэрэглэхэд илүү тохиромжтой гэж үзэж байна.

Түүнчлэн үйл ажиллагааны судалгаа нь уян хатан шинжтэй, нэг удаа судлаад зогсолгүй харин тухайн асуудал шийдвэрлэгдсэн байдлаас шалтгаалан давтан хийгддэг, мөн оролцоог эрхэмлэдэг тул илүү ардчилсан байдгаараа давуу талтай. Ялангуяа, хийж байж л мэдэж авна, хийнгээ суралцах хамгийн сайн арга гэсэн итгэл дээр суурилдаг, хувь хүний ажил, амьдралын туршилагыг судлаачийн мэдлэгтэй дүйцэхүйц адил түвшинд авчирч үнэлдэгээрээ дэвшилттэй гэж үзэж байна. Хэдийгээр Монгол улс хөгжиж буй орон гэдэг утгаараа ядуурлыг

бууруулах зорилгын хүрээнд үйлажиллагааны оролцоот судалгааг ялангуяа баг, сум, хороо зэрэг засаг захиргааны жижиг түвшинд хэрэгжүүлбэл илүү тохиromжтой боловч цаашилаад төрийн байгууллагын бүх шатны түвшинд тухайн байгууллага тулгамдсан асуудлаа шийдвэрлэх, өөрчлөлт хийх нэг арга болгон ашиглавал баагүй үр дүнд хүрч болох юм. Боловсролын салбарт энэ талаархи туршлага арай арвин байdag. Түүнчлэн бусад орны жишээнээс харахад бизнесийн байгууллага ч уг аргачлалыг ашиглах боломжтой. Ер нь тохиолдолд оролцогчдод арга зүйн туслалцаа дэмжлэг шаардагдах бөгөөд нийгмийн ухааны чиглэлээр судлаач бэлтгэдэг сургууль, тэнхимүүд энэ чиглэлийн хэрэгцээг зориуд судлан үзэх нь зүйтэй гэж бодож байна. Мөн Монголд үйл ажиллагааны судалгааны аргачлал ашиглан хийгдсэн судалгаануудыг цуглувж, арга зүйн талаас нь болон хэрэглэгдэж буй салбараар ангилан дүн шинжилгээ хийж үзвэл уг аргачлалыг системтэй хөгжүүлэхэд тустай юм.

Ашигласан материал

Argyris, C., Putnam, R. and Smith, D., (1985) *Action Science: Concepts, Methods and Skills for Research and Intervention*, San Francisco: Jossey-Bass.

Brydon-Miller M, Greenwood D, Maguire P, (2003), Why Action Research?, *Action Research*, 1 (1), 9-28

Dick, B., (2004), Action Research Literature: Themes and trends, *Action Research*, 2(4), 425-444
Dick, B., (2006), Action Research Literature 2004-2006: Themes and trends, *Action Research*, 4(4), 439-458

Fals Borda, O., (2006), Participatory (Action) Research in Social Theory: Origins and Challenges, in P.Reason & H.Bradbury (Eds), *Handbook of Action Research* (pp.27-37), Sage Publications

Flood, L., (2006), The Relationship of 'Systems Thinking' to Action Research, in P.Reason & H.Bradbury (Eds), *Handbook of Action Research* (pp.117-128), Sage Publications

Friedman, V., (2006), Action Science: Creating Communities of Inquiry in Communities of Practice, in P.Reason & H.Bradbury (Eds), *Handbook of Action Research* (pp.131-143), Sage Publications

Greenwood, D., Levin, M., (2007), *Introduction to Action Research: Social Research for Social Change*, 2nd edition, Sage Publications

Herr, K., Anderson, G.L., (2005), *The Action Research Dissertation: A Guide for Students and Faculty*, Sage Publications

Lewin, K., (1946), Action Research and Minority Problems, *Journal of Social Issues*, 2(4), 34-46

Pasmore, W., (2006), Action Research in the Workplace: the Socio-technical Perspective, in P.Reason & H.Bradbury (Eds), *Handbook of Action Research* (pp.38-48), Sage Publications

Reason, P., Bradbury H, (Eds) (2006), *Handbook of Action Research*, Sage Publications

Reason, P., (2003), Pragmatist Philosophy and Action Research: Readings and Conversations with Richard Rorty, *Action Research*, 1(1), 103-123

Somekh, B., (2006), *Action Research: a Methodology for Change and Development*, Open University Press

Ykhanbai, H., Odgerel, Ts., Bulgan. E., and Naranchimeg, B., (2006), Herder women speak out: towards more equitable co-management of grasslands and other natural resources in Mongolia, in Verwooy, R (Ed) *Social and Gender Analysis in Natural Resource Management: Learning Studies and Lessons from Asia*, Sage Publications